

**БАТЛАВ  
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД  
ХЭРГИЙН САЙД**



**Х.НЯМБААТАР**

**УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН  
ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага**

1.Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.1.1-д “... иргэд нэг удаа бүртгүүлээд төрийн цахим үйлчилгээг шуурхай авдаг болох зорилтыг бүрэн хэрэгжүүлж, “Нэг иргэн-нэг бүртгэл” арга хэмжээг үргэлжлүүлэн, төрийн цахим үйлчилгээг нэгдсэн стандартад оруулна” гэж, 4.1.2-т “Хүний эрхийг дээдэлсэн, цахим засаглалыг дэмжсэн, технологийн аюулгүй, зохистой харилцааг зохицуулсан хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж ... гаргана” гэж, 4.1.3-т “Цахим засаглалын тогтолцоог боловсронгуй болгож, технологийн дэд бүтэц, төрийн цахим үйлчилгээг нэгдсэн бодлого, төлөвлөлттэй хөгжүүлнэ” гэж тус тус заасан.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2018 оны 38 дугаар тогтоолоор Цахим бодлогын түр хороог байгуулж, тус хорооны 2019 оны 6 дугаар сарын 05-ны өдрийн хурлын шийдвэрээр “нэг иргэн, нэг бүртгэл” хөтөлбөрийн хүрээнд төрөлжсөн бүртгэлийн мэдээллийг иргэний бүртгэлийн дугаарт үндэслэн бүртгэж, ашиглах асуудлыг судалж, шийдвэрлэх үүргийг Засгийн газарт чиглэл болгосон. Түүнчлэн Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 4.1.1 дэх зорилтын 7-д “Иргэний улсын бүртгэлийн дугаар болон тоон гарын үсгийг улсын болон төрөлжсөн бүртгэлийн үйлчилгээнд бүрэн нэвтрүүлэн бүртгэлжүүлнэ” гэж тусгасан нь уг хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

2.Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 12 дугаар зүйлд улсын бүртгэлийн нэгдсэн сангийн мэдээллийг нээлттэй, хязгаартай, хаалттай байхаар тогтоож, мэдээллийн нэгдсэн сангаас мэдээлэл, лавлагаа олгохоор, мөн хуулийн 12 дугаар зүйлийн 12.2, 12.3 дахь хэсэгт заасан улсын бүртгэлийн нээлттэй, хаалттай мэдээллээс бусад улсын бүртгэлийн мэдээллийг хязгаартай мэдээлэл байхаар заасан бөгөөд түүнийг зөвхөн тухайн иргэний зөвшөөрлөөр өгөхөөр зохицуулсан.

Гэтэл хязгаартай мэдээлэл буюу регистрийн дугаар нь Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.3 дахь заалтад заасны дагуу иргэний үнэмлэхэд ил харагдаж бичигдэхээр, Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.12 дахь хэсэгт “Монгол Улсын иргэн бүр регистрийн дугаартай байх бөгөөд уг дугаар нь төрсний, гэрлэсний, нас барсны улсын бүртгэлийн гэрчилгээ, иргэний үнэмлэх, үндэсний гадаад паспорт, тэдгээртэй адилтгах баримт бичигт бичигдэнэ” гэж тус тус заасан. Мөн Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль зэрэг хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиудад регистрийн дугаарыг шаардаж, аливаа

мэдээлэл, баримт бичигт тусгахаар нийт 27 хуулийн 48 зүйл, 29 хэсэг, 45 заалтад<sup>1</sup> тусгасан байна.

Регистрийн дугаарыг Монгол Улсын иргэн төрсний бүртгэлд анх удаа бүртгүүлэх, Монгол Улсын харьяат болоход олгож байгаа бөгөөд тухайн иргэнд олгосон регистрийн дугаар нь олгосон аймаг, нийслэл, сум, дүүргийг илэрхийлсэн үсгэн утга, төрсөн он, сар, өдөр, хүйсийг илэрхийлсэн тоон утгыг агуулж байдаг тул регистрийн дугаараар тухайн иргэний төрсөн он, сар, өдөр, хүйсийн мэдээлэл, оршин сууж байсан аймаг, нийслэл, сум, дүүргийн мэдээллийг мэдэх боломжтой байдаг.

Иймд одоогийн хуулиар регистрийн дугаарыг ил харагдах бичилтээр бичиж байгаа эрх зүйн зохицуулалтыг өөрчилж, Монгол Улсын Их Хурлын 2009 оны “Иргэний шинэчилсэн бүртгэл явуулах тухай” 100 дугаар тогтоолд заасны дагуу иргэний биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд бүртгүүлсэн Монгол Улсын нийт насанд хүрсэн иргэдийн 98 хувь буюу 1,925,772 иргэнд иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сангаас өгөгдсөн 12 орон бүхий тоо болох иргэний бүртгэлийн дугаарыг иргэний бүртгэлийн холбогдох баримт бичигт ил харагдах бичилтээр тусгах нь зүйтэй гэж үзэж байна. Үүнтэй уялдуулан иргэний үнэмлэхийн санах ойд иргэний овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, иргэний бүртгэлийн болон регистрийн дугаар, хүйс, оршин суугаа газрын хаяг, тоон гарын үсгийн мэдээллийг тусгахаар тогтооно.

2.Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.8 дахь заалтад Монгол Улсын иргэдэд олгогдож буй иргэний үнэмлэх дээр иргэний оршин суугаа газрын хаягийн мэдээлэл ил харагдах бичилтээр хийхээр заасан.

Иргэний оршин суугаа газрын хаягийн мэдээлэл уг хуулийн дагуу иргэний үнэмлэхэд ил бичигдсэнээр бодит байдал дээр иргэдэд багагүй хүндрэл бэрхшээлийг бий болгодог. Тухайлбал, Иргэний улсын бүртгэлийн тоон мэдээ, судалгаанаас үзэхэд нэг жилд дундажаар 16 ба түүнээс дээш насны 120000-130000 иргэн шилжилт хөдөлгөөний бүртгэлд бүртгүүлж, мэдээллийн санд тухайн иргэний оршин суугаа газрын хаягийг өөрчилж, мэдээллийн санд тусгадаг бөгөөд энэ хаяг нь иргэний үнэмлэхэд бичигдсэн хаягаас зөрүүтэй болдог тул иргэн шилжилт хөдөлгөөний бүртгэлд бүртгүүлж, иргэний оршин суугаа газрын хаяг өөрчлөгдөх тохиолдолд бүрт иргэний үнэмлэх сольж авах хэрэгцээ шаардлага үүсэж байна.

Мөн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр засаг захиргааны нэгжийн бүтцэд өөрчлөлт оруулах тохиолдолд иргэний оршин суугаа газрын хаяг өөрчлөгдөж, тухайн иргэний гар дээрх баримт бичгээс зөрүүтэй болох тохиолдлууд байсаар байна. Түүнчлэн иргэний оршин суугаа газрын хаягийн мэдээлэл иргэний үнэмлэхэд ил бичигдсэнээр бусад этгээд харах, иргэний хаягийн мэдээллийг ашиглан хохирол учруулах, иргэний хувийн аюулгүй байдал алдагдах зэрэг нөхцөл байдлыг бий болгосоор байна.

---

<sup>1</sup> Legalinfo.mn цахим хуудас, сүүлчийн нэвтрэлт 2020.12.30-ны өдөр. Нийт 767 хуулиас хайлт хийв.

Иймд иргэний улсын бүртгэлийн баримт бичгийн үнэн зөв байдлыг хангах, иргэнд эдийн засгийн аливаа дарамт, хүндрэл бэрхшээлийг учруулахгүй байх, бусад эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор иргэний оршин суугаа газрын хаягийн мэдээллийг иргэний үнэмлэхийн санах ойд тэмдэглэхээр тусгах нь зүйтэй гэж байна.

### **Хоёр.Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хуулийн зохицуулах харилцаа, хамрах хүрээ, агуулгад гарч буй өөрчлөлтийг харгалзан Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасны дагуу хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлбэрээр боловсруулах бөгөөд дараах зохицуулалтыг тусгана:

-иргэний бүртгэлийн дугаарыг иргэний үнэмлэх болон улсын бүртгэлийн байгууллагаас олгодог бусад бичиг баримтад тусгахаар өөрчлөлт оруулна;

-иргэний регистрийн дугаарыг Монгол Улсын иргэний үнэмлэхийн санах ойд тэмдэглэхээр тусгана;

-иргэний оршин суугаа газрын хаягийн мэдээллийг иргэний үнэмлэх дээр ил харагдах байдлаар бичсэнийг иргэний үнэмлэхийн санах ойд оруулахаар тусгана;

-иргэний бүртгэлийн дугаарт үндэслэн суурь болон төрөлжсөн мэдээллийн сан үүсгэж, төрийн үйлчилгээ үзүүлэхэд ашиглахаар тусгана.

### **Гурав.Хуулийн төсөл батлагдсан дараа үүсэж болох нийгэм, эдийн засгийн үр дагавар**

Хуулийн төсөл батлагдсанаар хуулийн хэрэгжилт, үр нөлөө сайжирч, дараах эерэг үр дүн гарна гэж тооцоолж байна:

1/Иргэний бүртгэлийн дугаарыг иргэний үнэмлэхийн ил харагдах бичилт хийх мэдээлэлд тусгаж, регистрийн дугаарыг иргэний үнэмлэхийн санах ойд тэмдэглэснээр хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хуулиар хязгаарлаж тогтоосон иргэний мэдээллийн нууцлалыг хадгалах нөхцөл бүрдэнэ;

2/Иргэний бүртгэлийн дугаарыг хэрэглээнд нэвтрүүлснээр төрөөс үзүүлж буй үйлчилгээ болон төрийн байгууллага хооронд мэдээлэл солилцоход өөрчлөгддөггүй, дахин олгодоггүй, давхарддаггүй, сольдоггүй, нэгдсэн нэг дугаар ашиглах боломжтой болж, үнэн зөв, нэг эх сурвалжийн мэдээлэлд үндэслэн иргэний үнэмлэхийн хэрэглээг нэмэгдүүлэх замаар төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр түргэн шуурхай, хүртээмжтэй үзүүлнэ;

3/хуулийн зөрчил, хийдэл арилж, хуулийн зохицуулалт боловсронгуй болж, хуулийг нэг мөр ойлгож, хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ;

4/иргэний оршин суугаа газрын хаягийн мэдээллийг иргэний үнэмлэх дээр ил харагдах байдлаар бичсэнийг иргэний үнэмлэхийн санах ойд оруулснаар иргэний хувийн мэдээллийн аюулгүй байдал хангагдана.

Хуулийн төсөл батлагдсанаар улсын төсөвт нэмэлт ачаалал үүсгэхгүй.

**Дөрөв.Хуулийн төсөл нь бусад холбогдох хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтай холбогдон цаашид шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар**

Энэхүү хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, Хууль тогтоомжийн тухай болон холбогдох бусад хууль тогтоомжтой нийцсэн болно.

Хуулийн төсөлтэй холбогдуулан зарим нэр томъёог жигдлэх зорилгоор бусад хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

---o0o---